“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурлын тэмдэглэл

2018 оны 07 сарын 27-ны өдөр Улаанбаатар хот

“Монгол Базальт” ХК-ийн 2018.07.27 –ны өдрийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурал Улаанбаатар, ХУД, 15-р хороо, Корпорейт Конвейшн центрийн хурлын танхимд хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 13 цагаас эхлүүлж, хурлын ирцийг 14:20 танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал эхлэв.

Хурлын дарга: А.Энхгэрэл

Хурлын ирц: 72.80 хувьтай

Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчид хүрэлцэн ирсэн байна.

Хурлын дарга А.Энхгэрэл хурлын ирц бүрдсэнийг хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэж хурлын дэгийг танилцуулан “ Монгол Базальт” ХК-ийн ерөнхий захирал Л. Ариунболд хурал нээж үг хэлэв.

Ерөнхий захирал Л.Ариунболд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нарт хүрэлцэн ирсэнд талархан үг хэлж хурлыг нээснийг мэдэгдсэнээр хурал эхлэв.

Хурлаар танилцуулсан асуудал:

1. Компанийн товч танилцуулга / А. Энхгэрэл танилцуулав./
2. Хагас жилийн үйл ажиллагааны тайлан / Л.Ариунболд танилцуулав./
   - ✓ Шүршдэг базальт хөвөн нэвтрүүлсэн
   - ✓ Хаан болон Хас банктай хамтран ногоон зээл төсөл хэрэгжүүлсэнээр зах зээлд өсөлт авчирсан / 30 сая төгрөг төвлөрүүлсэн./
   - ✓ Хүний нөөц
   - ✓ Бүтээгдэхүүн
   - ✓ Бүс нутагт өөрсдийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг жижиг дунд үйлдвэрлэгч нарт нийлүүлэх төлөвлөгөөтэй
   - ✓ Дүргүүдэд иргэд нарт чиглэсэн сургалт явуулж байна.
   - ✓ Хагас жилийн дотоод борлуулалтын гэрээ
   - ✓ Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхантай үйлдвэр танилцуулан , уулзалт зохион байгуулсан.
   - ✓ 6,7 сард гадаадаас төлөөлөгч нар хүрэлцэн ирж Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатартай уулзалт зохион байгуулсан.
   - ✓ Гадаадын төлөөлөгч нартай үйлдвэрийн үйлдвэрийн тоног төхөөрөмж хөгжүүлэх, Япон болон БНХАУ-руу бүтээгдэхүүн экспортлох төлөвлөгөө гаргасан.
3. Хөрөнгө оруулалтын зарцуулалт / А. Энхгэрэл танилцуулав/
4. 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан / А. Энхгэрэл танилцуулав/
   - ✓ Хувьцаа эзэмигч нарын бүтэц
   - ✓ Хүний нөөц, менежментийн төлөвлөгөө
   - ✓ Дотоот сургалт , маркетинг төлөвлөгөө
   - ✓ Хагас жилийн олон улсын маркетинг төлөвлөгөө

Хурлаар хэлэлцсэн асуудал: / 15 цаг 10 минутанд дараах асуудлуудыг хэлэлцэж эхлэв./

1. Компанийн шинэчилсэн дүрэм
2. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийг танилцуулав. Үүнд:
   Ердийн 6 гишүүн:
   Л.Ариунболд
   Г.Ганзориг
   А.Энхгэрэл
   П.Сайнбилэг
   Ш.Батжаргал
   Б.Шаравсамбуу
   Хараат бус 3 гишүүн байна:
   Ш.Энхтөр
   Т.Цэнд-Аюуш
   Ч.Зоригтбаатар
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулал
4. Хувьцаа эзэмшигч нараас нэмэлт асуулт, хариулт, санал өгөв.

Хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар хэлэлцэж буй асуудлуудад саналаа өгөв.

Тооллогын комисс саналын дүнг нэгтгэн танилцуулав.Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн 99.5 хувь зөвшөөрснөөр компанийн шинэчилсэн дүрэм батлав.

2. Хувьцаа эзэмшигчдийн 99.4 хувь зөвшөөрснөөр ТУЗ-н гишүүдийн цалин урамшууллыг батлав.

3. ТУЗ-ийн гишүүдээр:

ТУЗ-н ердийн гишүүнээр:

Л. Ариунболд-17.51%

Г.Ганзориг-16.06%

А.Энхгэрэл-16.08%

П.Сайнбилэг-16.07%

Ш.Батжаргал-17.24%

Б.Шаравсамбуу-16.08%

ТУЗ-н хараат бус гишүүнээр:

Ш.Энхтөр-33.51%

Ч.Зоригтбаатар-32.14%

Т.Цэнд-Аюуш-33.38 хувийн саналаар тус тус сонгогдсоныг хурлын дарга А.Энхгэрэл танилцуулан 17 цаг 30 минутанд хурлыг хаав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: /Х.Одончимэг/

Хурлын дарга: /А.Энхгэрэл/